



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 4/11

Жаргалант

┌ Сумын 2015 оны төсөв батлах тухай ┐

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын 2015 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

	<b>Сумын төсвийн орлого бүгд</b>	1469810,0
1	<b>Урсгал орлого</b>	17550,0
1.1	<b>Сумын татварын орлого</b>	13950,0
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	
1.1.2	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	10000,0
1.1.3	Бууны албан татвар	850,0
1.1.4	Нохойны албан татвар	300,0
1.1.5	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	2000,0
1.1.6	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	
1.1.7	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	100,0
1.1.8	Байгалийн ургамал ашигласны төлбөр	
1.1.9	Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр	
1.1.10	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	
1.1.11	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	
1.1.12	Патент	700,0
1.1.13	Газрын төлбөр	
1.1.14	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	
1.2	<b>Сумын төсвийн татварын бус орлого</b>	3600,0

1.2.1	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг	
1.2.2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр	
1.2.3	Хүү, торгуулийн орлого	3000.0
1.2.4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	600.0
1.2.5	Хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого	
1.2.6	Өмч хувьчлалын орлого	
2	<b>Хөрөнгийн орлого</b>	
2.1	Хөрөнгө борлуулсны орлого	
3	<b>Тусламжийн орлого</b>	1452260,0
3.1	Хандив тусламжийн орлого	
3.2	Санхүүгийн дэмжлэг	277904,1
3.3	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	251235,0
3.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	923120,9

2.Сумын 2015 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

2.1	<b>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга</b>	
2.1.1	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	
2.2	<b>Засаг дарга</b>	600,0
2.21	Харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлого	
2.2.2	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	600,0
2.3	<b>Сургуулийн захирал</b>	300,0
2.3.1	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	300,0
2.4	<b>Цэцэрлэгийн эрхлэгч</b>	
2.4.1	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	
2.5	<b>Соёлын төвийн эрхлэгч</b>	1158,7
2.5.1	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	<del>47,7</del>

3.Сумын 2015 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

3.1	<b>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга</b>	43052.6
3.1.1	Урсгал зардлын дээд хэмжээ	43052.6
3.1.2	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	
3.2	<b>Засаг дарга</b>	1175522,4
3.2.1	Урсгал зардлын дээд хэмжээ	252401.5
3.2.2	Үүнээс: Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт байгууллагад олгох тусгай зориулалтын	923120.9

	шилжүүлгийн хэмжээ	
3.3	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	251235.0

4.Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

4.1	Сургууль	645666.9
4.2	Цэцэрлэг	225793.4
4.3	Соёлын төв	51660.6

5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

6.ИТХ, ЗДТГ, багийн төсвийн орлогын нэр, төрөл хэмжээг 2 дугаар хавсралтаар баталсугай.

7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг 251235.0 төгрөгөөр баталж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, санхүүжилтын дүнгийн жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР





Сумын ИТХ-ын хуралдааны 2014 оны  
4/11 -р тогтоолын 1 дүгээр хавсралт



**ТӨСВИЙН ЭРХ ЗАХИРАГЧ НАРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН**

Д/д	Төсвийн захирагч тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	эрх нар	Хүрэх үр дүн		Зарцуулах төсөв /сая төгрөг/
			Чанар	Тоо	
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга				43052,6
1.1	Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих	Монгол Улсын 33НДНТУТХ болон Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх	Улсын болон хуралдах	2-оос доошгүй удаа	
1.2	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Хэрэгжилтийг ханган ажиллах	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих	Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих	
1.3	Ил тод нээлттэй байдлыг бүх талаар хангах	Орон нутгийн нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэх	Иргэдийн үзэл бодол ашиг сонирхолыг төр засгийн бодлогод тусгаснаар иргэдийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх	Иргэдийн үзэл бодол ашиг сонирхолыг төр засгийн бодлогод тусгаснаар иргэдийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх	
1.4	Хамтын ажиллагааг өргөжүүлэх	НӨУ болон төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан туршлага солилцох	Аймаг, зэргэлдээ сумдын нутгийн өөрөө удирдах байгууллагуудын ажлын арга туршлагаас судлах	Аймаг, зэргэлдээ сумдын нутгийн өөрөө удирдах байгууллагуудын ажлын арга туршлагаас судлах	
1.5	Төсөв ба иргэдийн оролцоо	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд оролцох иргэдийн оролцоог 80 хувьд хүргэх	Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга, иргэдэд сургалт хийх	Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга, иргэдэд сургалт хийх	43052,6
1.6	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	ИТХ-ын цахим хуудсыг ажиллуулан иргэдийн санал бодлыг тусган хэрэгжүүлэх	Ил тод, нээлттэй байдлыг ханган, хурлын шийдвэрт тэдний санал бодлыг тусгах, сургалт сурталчилгааг тогтолжуулах	Ил тод, нээлттэй байдлыг ханган, хурлын шийдвэрт тэдний санал бодлыг тусгах, сургалт сурталчилгааг тогтолжуулах	
1.7	Төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сургалт сурталчилгаа	ИТХ-ын Төлөөлөгчид, төрийн албан хаагчид, иргэдийн боловсролыг нэмэгдүүлэх	Хурлын Төлөөлөгчид, төрийн албан хаагчид, иргэдэд хууль эрх зүйн сургалт зохион байгуулах, тэдний хооронд уралдаан тэмцээн зохион байгуулах	Хурлын Төлөөлөгчид, төрийн албан хаагчид, иргэдэд хууль эрх зүйн сургалт зохион байгуулах, тэдний хооронд уралдаан тэмцээн зохион байгуулах	
1.8	Гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх ажлыг зохион байгуулах	Гэмт хэрэг гаралтын шалтгаан нөхцлийг тогтоон, бууруулах	Иргэдэд хууль эрх зүйн сургалт, сурталчилгааг тогтмол явуулах	Иргэдэд хууль эрх зүйн сургалт, сурталчилгааг тогтмол явуулах	
1.9	БИНХ-ын үйл ажиллагаа	ИНХ-ын үйл ажиллагааг тогтмолжуулан, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	БИНХ-ыг 2-оос доошгүй хуралдуулах, сургалт мэдээллийг тогтмолжуулах	БИНХ-ыг 2-оос доошгүй хуралдуулах, сургалт мэдээллийг тогтмолжуулах	



1.10	Байгаль орчноо хамгаалах хөтөлбөр	Байгалийн эсрэг гэмт үйлдлийг таслан зогсоох	Хяналт шалгалтыг тогтмолжуулж ажиллах	
2.1	Сумын Засаг дарга			252401,5
2.1.1	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн хөгжлийг бодлогоор дэмжих	Мал түүхий эдийн бирж байгуулан, мал түүхий эдийг сум орон нутагт худалдан авах, борлуулах	252401,5
2.1.2	Газар тариаланг хөгжүүлэх	Газар тариалан эрхлэлтийг байраар дэмжих	Хадлангийн 3 салааны үйл ажиллагааг дэмжиж суманд өвсний нөөцтэй болох	
2.1.3	Нийтийн аж ахуйг байгуулж, дэмжих	Сум орон нутгийн хөгжлийг дэмжих	Нийгэм, ахуй үйлчилгээ, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах	
2.1.4	Байгаль хамгаалах хөтөлбөр	Байгаль орчноо хайрлан хамгаалах ажилд малчид иргэдийн өөрсдийн идэвх санаачлагыг өрнүүлэх	Сургалт сурталчилгааг тогтмол явуулж байгалийн эсрэг гэмт үйлдлийг таслан зогсоох, сурагчдад байгаль орчноо хамгаалах үзэл бодлыг төлөвшүүлэх	
2.1.5	Гамшгаас хамгаалах	Гамшгаас хамгаалах бодлогыг дэмжих	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх	
2.1.6	Сургалт сурталчилгаа, өрхийн мэдээллийн сан	Мэдээллийн санг 100 хувь хүргэх	Төрийн бодлого шийдвэр, аймаг, сумын нутгийн захиргааны байгууллагын хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, сумын төсөвт байгууллагуудын мэдээллийг хүргэх, хууль эрх зүйн сургалт сурталчилгаа зохион байгуулах	
2.1.7	Төрийн бодлого шийдвэрийг сурталчлах	Төрийн бодлого иргэдэд хүргэх	УИХ, МУЗГ, аймаг, сумын ИТХ, Засаг даргаас тогтоол, шийдвэр, захирамжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах	
2.1.8	Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх	Үндсэн чиглэлийн биелэлтийг хангах	Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх	
2.1.9	Сумын Засаг даргын үйл ажиллаганы хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хөтөлбөрийн биеэлтийг хангах	Сумын Засаг даргын үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх	
2.1.10	Цэрэг, батлан хамгаалах, арга хэмжээг зохион байгуулах	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах	Цэрэг татлага, тоо бүртгэл, дайчилгаа, дадлага, сургалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх	
2.2.1	Засаг захиргааны анхан шатны нэгж, багийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Багаас иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах	Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх	
2.2.2	Багийн өрхийн нийгэм, эдийн засгийн төрөл бүрийн судалгаа	Нийгмийн бүх төрлийн судалгаа, тайлан мэдээг нарийвчлан гаргах	Багийн цахим мэдээллийн санг бий болгоно	


2.2.3	Төрийн бодлого шийдвэрийг сурталчлах	Багийн иргэдэд төрийн бодлого шийдвэрийг хүргэх	Иргэдийг мэдээлээр бүрэн хангах, санал хүсэлтийг авах	
2.3	Нийгмийн халамжийн зардал	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулах	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулах	
3.1	Аймаг, дүүргийн Засаг даргаас гэрээгээр авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			
3.1.1	Ерөнхий боловсролын үйлчилгээ	Сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах	Сургуулийн тоо 1	645666,9
3.1.2	Соёл урлагийн үйлчилгээ	Соёл урлагийн үйлчилгээний хамралт, хүртээмжийг нэмэгдүүлэх	Соёлын төвийн тоо 1	225793,4
3.1.3	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах	Цэцэрлэгийн тоо 1	51660,6



Сумын ИТХ-ын хуралдааны 2014 оны  
4/11 -р тогтоолын 2 дугаар хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН  
2015 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСӨВ**

№	Зардлынзүйл	ИТХ	ЗДТГ	БАГ
1	Цалин	23493.11	129122.1	32546.6
2	ИНХ урамшуулал	7972.0		
3	Гэрээтажилчдынцалин		12605.1	
4	Шимтгэл	3461.1	15590.0	3580.1
5	Гэрэлцахилгаан		1842.6	347.8
6	Түлшхалаалт		8000.0	1000.0
7	Холбоо	540.0	400.0	250.0
8	Гэрээтцалин			
9	Бичигхэрэг	417.6	1704.0	700.0
10	Шатахуун	1200.0	12000.0	2700.0
11	Номхэвлэл	100.0	360.0	360.0
12	Урсгалзасвар		500.0	50.0
13	Нормынхувцас		250.0	
14	Томилолт	1000.0	7800.0	700.0
15	Нэгүдаагийнтэтгэмж	100.0	2000.0	300.0
16	Төлбөрхураамж	150.0	600.0	180.0
17	Малтооллогозардал			
18	Биеийнтамирынуралдаан		2400.0	
19	Хуралдаанызардал	600.0		
20	Сургалт, семинар	80.0	500.0	250.0
21	Эдхогшил		2000.0	
22	Шагналурамшил	600.0		
23	Гэрээт НДШ			
24	Тэтгэмж /ажилгүйдлийн/	3038.7	2703.2	
25	ГХУСАЗСЗ зардал	200.0		
26	Гамшиг			
27	Мэдээлэлсурталчилгаа	100.0	500.0	
28	Батланхамгаалах		200.0	
29	Засагдаргыннөөц		6160.0	2200.0
30	Сэлбэг			
31	Программ			
	<b>Санхүүгийн дэмжлэг</b>	43052.5	189687.0	45164.5
	<b>ОН ороогоос</b>		17550.0	
	<b>Нийт</b>	43052.5	207237.00	45164.5



**СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
	<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>
	<b>Хөрөнгө оруулалт</b>		<b>251235000</b>	<b>251235000</b>
1	Нийтийн биеийн тамирын талбайн дутуу санхүүжилт	2015	471079	471049
2	Сум дундын эмнэлэгт Шүдний тоног төхөөрөмж	2015	14200000	14200000
3	Өвс тэжээлийн агуулахын барилгын дутуу санхүүжилт	2015	4773708	4773708
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сувилалын дутуу санхүүжилт	2015	7778345	7778345
5	Төвлөрсөн халаалтын зураг төсөв	2015	25000000	25000000
6	Гудамжны гэрэлтүүлэг хийх	2015	28000000	28000000
7	Зам засвар /2, 3-р багт/	2015	10000000	10000000
8	Худаг засвар /1, 2, 3, 4-р багт/	2015	14653904	14653904
9	Ахуй үйлчилгээний барилгын дутуу санхүүжилт	2015	2579755	2579755
10	Төв зам-Явган хүний зам	2015	15000000	15000000
11	Интернетийн өргөтгөл	2015	23000000	23000000
12	Улсын баяр наадмын зардал	2015	5000000	5000000
13	Бэлчээрийн нөхцөлийг сайжруулах /Оготно устгах/	2015	22000000	22000000
14	Халуун усны барилгын засвар	2015	10000000	10000000
15	Гүний худаг гаргах /1 худаг/	2015	20000000	20000000
16	Нийтийн ариун цэврийн цэг тохижуулах /стандартын хогийн сав/	2015	5000000	5000000
17	Малын эрүүл мэндийг сайжруулах/зөөврийн тарилгын хашаа 2 ширхэг/	2015	5000000	5000000
18	Гамшигийн сан	2015	7396000	7396000
19	Цэцэрлэгийн байрны цахилгааны засвар	2015	2000000	2000000
20	Хог тээврийн машины засвар	2015	2000000	2000000
21	Нийтийн биеийн тамирын талбайн өргөтгөл	2015	8482239	8482239
22	Сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дутуу санхүүжилт	2015	9500000	9500000
23	Сургуулийн хичээлийн байрны тохижилт, засвар	2015	4400000	4400000
24	Хүчирхийлэлээс хамгаалах байрны засвар, тохижилт	2015	5000000	5000000
	<b>Нийт дүн</b>		<b>251235000</b>	<b>251235000</b>





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 4/12

Жаргалант

2014 оны давсан орлого хуваарилах тухай

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Б" заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн давсан орлого 5000000 төгрөгийг дараах байгууллагад нэмэлт тодотгол хийсүгэй. Үүнд:

№	Зардлын зүйл	ИТХ	ЗДТГ
1	Шагнал урамшуулал	1250,0	
2	Урсгал засвар	750,0	
3	Шатахуун		195,0
4	Аж ахуйн эд хогшил		2805,0
	Нийт	2000,0	3000,0

2.Төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга Д.Сайнбилэг, Төрийн сангийн төлөөлөгч Д.Азжаргал нарт даалгасугай.

ДАРГА  Д.АНТӨМӨР





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар

4/13

Жаргалант

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1.8 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хяналтын зардалд 1560,0 /нэг сая таван зуун жаран мянга/ төгрөгийг зарцуулахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийг зориулалтын дагуу үйл ажиллагаандаа зарцуулахыг сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийн дарга Н.Ганжаргалд даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР







**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 2/14

Жаргалант

Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх  
2014 оны үндсэн чиглэлийн биелэлт,  
2015 оны үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2а заалтыг үндэслэн сумын ИТХ-ын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 84 хувь буюу хангалттай гэж дүгнэсүгэй.

2. Сумын нийгэм, эдийн засгийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Үндсэн чиглэлийг аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд сурталчилж, хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын тамгын газар, сумын Засаг дарга /Д.Сайнбилэгт/-д даалгасугай.



ДАРГА *[Signature]* Д. ГАНТӨМӨР

1513071 togtool-2014

Сумын ИТХ-ын хуралдааны 2014 оны  
4/14 дүгээр тогтоолын хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
2015 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

№	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2015 онд хүрэх түвшин, үр дүн	2015 онд хөрөнгийн эх үүсвэр /сая төгрөг/	Хариуцах байгууллага
<b>НЭГ.НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР</b>					
<b>1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмж:</b>					
1	2	3	4	5	6
1.1.1	Төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор төсвийг гүйцэтгэл мэдээ тайланг сар бүр мэдээллийн самбарт байршуулж, товхимол хэлбэрээр гаргаж иргэдийг мэдээллээр хангах	Хэрэглэгчдийг мэдээллээр бүрэн хангана.	Сар бүр мэдээллийн самбарт байрлуулж, иргэдийг мэдээллээр хангасан байна.		Төрийн сангийн мэргэжилтэн, Төсөвт байгууллагуудын ня-бо нар
1.1.2	Төсөв санхүүгийн шинэчлэлийн ажлын хүрээнд байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дотоод аудитыг гүйцэтгэж үр дүнг тооцон ажиллана.	Улирал бүр дотоод аудит хийнэ	Төсөвт байгууллагууд санхүүгийн зөрчилгүй болсон байна		Тамгын газрын дарга, Төрийн сан
1.1.3	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт, сум, багийн Засаг дарга нарт зориулсан сургалтанд бүрэн хамруулах	Төрийн албан хаагчдыг сургалтанд бүрэн хамруулсан байна	Сургалтанд хамрагдсан төрийн албан хаагчдын ёс зүй мэргэшил дээшилж иргэдэд хөнгөн шуурхай үйлчилдэг болно.		Тамгын газрын дарга

1.1.4	Өрхтэй харилцах дэвтэрийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Өрх бүр дэвтэр ашиглаж сурсан байна.	Төр иргэдийн уялдаа холбоо сайжирна		Багийн засаг дарга нар
1.1.5	2014 оны үндсэн чиглэлийн биелэлт, 2015 оны үндсэн чиглэлийг өрх бүрт хүргэх	Мэдээллийг өрх бүрт хүргэнэ	Сумын Төрийн байгууллагуудаас хийж хэрэгжүүлсэн ажлууд болон хийх ажлын төлөвлөгөөг иргэн бүр мэдсэн байна.	Бичиг хэргийн зардалаас	Сумын Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга
1.1.6	Суманд ажиллаж буй Төрийн албан хаагчдын дунд сахилга хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулж явуулах	Төрийн албаны стандарт мөрдөлт сайжирна.	Төрийн албан хаагчтай холбоотой зөрчил арилна.		Сумын Засаг дарга, Тамгын газрын дарга
1.1.7	Сумын 2013, 2014 оны үйл ажиллагааны тайлангаар сэтгүүл гаргаж өрх бүрт хүргэх	Сэтгүүлийг өрх бүрт хүргэнэ	Төр иргэдийн уялдаа холбоо сайжирна		Засаг даргын Тамгын газар
<b>2.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрх зүйн сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулах:</b>					
1.2.1	Хүний эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Албан байгууллагууд зөвлөл байгуулж, төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажиллана	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, гэмт хэргийн гаралт буурна.		Тамгын газрын дарга, Төсөвт албан байгууллагуудын дарга, эрхлэгч
1.2.2	"Хууль бидний амьдралд" хуулиа сурталчилах ажлыг бүх багуудад зохион байгуулах	Сумын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцно	Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилж, гэмт хэргийн гаралт буурна.		Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нар, Нийгмийн түншлэлийн баг, Цагдаагийн хэсэг
1.2.3	2015 оны Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж ажиллана	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах хуулийг мөрдөж ажиллана	нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй болгоно		Тамгын газрын дарга



1.2.4	“Архигүй Монгол хүн” хөтөлбөрийг зан үйл, мэдлэг хандлага, судалгаан дээр үндэслэн соён гэгээрүүлэх ажлыг хийх “Эрүүл хэрэглээтэй” иргэн, ТББ, олон нийтийн байгууллага, хамт олныг урамшуулж ажиллана	Хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана	Хүмүүсийн хандлага өөрчилөгдсөн байна		Төрийн болон төрийн бус байгууллагуудын дарга, эрхлэгч, Нийгмийн түншлэлийн баг
<b>3.Батлан хамгаалах:</b>					
1.3.1	2015 оны цэрэг татлага болон цэргийн албыг дүйцүүлэн хаах болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах хэлбэрүүдийг хууль дүрэм журмын дагуу зохион байгуулах	Хууль дүрмийг мөрдөж ажиллах	Ээлжит цэрэг татлагыг чанартай зохион байгуулж, Аймаг, орон нутгийн бүтээн байгуулалт гамшгаас хамгаалах ажилд татан оролцуулна		Тамгын газрын дарга
1.3.2	Цэргийн насны залуучууд дунд сургалт зохион байгуулж, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулна	Арга хэмжээ зохион байгуулагдсанаар	Цэргийн насны залуучуудын зэвсэгт хүчний талаар мэдлэг дээшлэж, нийгмийн идэвх дээшилсэн байна		Тамгын газрын дарга
<b>Хоёр. Нийгмийн салбарыг хөгжүүлэх бодлого:</b>					
<b>1.Соёл, урлаг спортын талаар:</b>					
2.1.1	Номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, ном унших аяныг иргэдийн дунд тодорхой сэдвээр зохион байгуулж, оюуны эрэлт хэрэгцээг нь хангахад чиглүүлнэ.	Төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн дунд аян зарласан байна	Ном уншдаг иргэдийн тоо нэмэгдсэн байна		Соёлын төвийн номын санч, Сургуулийн номын санч
2.1.2	Эвдэрсэн сүйтгэгдсэн түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хайсжуулах, самбар тавих	Хадгалалт хамгаалалт сайжирсан байна.	Түүх соёлын үнэт дурсгалт зүйлсийн насжилт нэмэгдэж хойч үе түүх соёлоороо бахархаж судалгаа шинжилгээний судлагдахуун бий болно		Соёлын төв БОХУ-ын байцаагч
2.1.3	Соёлын байгууллагууд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах менежментийг боловсронгуй болгох	Үр дүнтэй менежментийг хэрэгжүүлсэн байна.	Төрийн болон хувийн хэвшлийн уялдаа холбоо сайжирна		Соёлын төв

2.1.4	Яруу найргийн өдөр "Уран үгсийн чуулган", "Хүрэн морь" яруу найргийн наадмыг зохион байгуулах	Яруу найргийн наадам зохион байгуулагдсан байна	Залуу хойч үедээ үндэсний яруу сайхан эх хэлээрээ бахархах, мөн гоо зүйн боловсрол хүмүүжил олгоно		Соёлын төв
2.1.5	"Эрүүл агаар эм" цас мөсны баяр	Цас мөсны баяр зохион байгуулсан байна	Байгууллага хамт олон, иргэд хөдөлмөрчдийн нийгмийн идэвх сайжирна		Соёлын төв, Залуучуудын холбоо
2.1.6	Нутгийн бренд болгох зорилгоор 200 хулсан хуурчийг бэлтгэх		Устаж үгүй болох аюулд орсон үндэсний өв соёлоо хойч үедээ уламжлан хадгалаж, өөрийн нутгийн өнгө төрх брендийг бий болгоно	.....	Соёлын төв
2.1.7	Уртын дуу, Ардын дууны сургалт зохион явуулах	Сургалт зохион байгуулагдсан байна	Хүүхэд залуучуудын дунд ардын урлагийг сонирхогчид нэмэгдсэн байна		Соёлын төв, Ахмадын холбоо
2.1.8	Ардын авьяастнуудыг оролцуулан бүрэн хэмжээний жүжиг тоглох	Жүжиг тоглогдсон байна	Жүжгийн урлагаар дамжуулан уран сайханчдыг чадавхжуулж, ард иргэдэд шинэлэг чанартай үйлчилгээ үзүүлнэ		Соёлын төв
2.1.9	Ардын авьяастануудыг оролцуулан хөдөөгийн багуудаар урлагийн тоглолт зохион байгуулах	Урлагийн тоглолтийг зохион байгуулсан байна	Хөдөөгийн малчид, соёлын байгууллагын уялдаа холбоо сайжирна		Соёлын төв
<b>2.Боловсролын байгууллагын талаар:</b>					
2.2.1	"Өвгөнжаргалант" зусланд хүүхдүүдийг амралт чөлөөт цагаа зөв өнгөрүүлж, амраах	10-20 хүүхэд Өвгөнжаргалант зусланд амраасан байна	Хүүхдүүд зуны амралтаараа зөв боловсон хүмүүжил олж авсан байна	Орон нутгийн хөгжлийн сангаас 3.250.000 төгрөг	ЗДТГ, Сургууль

2.2.2	“Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /“Боловсролын чанарын шинэчлэлийн хөтөлбөр”, “Ном” хөтөлбөр болон “Авъяас” хөтөлбөр агуулагдсан/	3 хөтөлбөр дэхь шалгуур үзүүлэлтийг хангасан байна.	Сурлагын амжилт ___ хувь байгааг ___ хувьд хүргэнэ. Дугуйлан сонгонд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оноос 10 хувиар өссөн байна.		“Байдраг” ахлах сургууль Цэцэрлэг
2.2.3	СӨБ-д хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, төрөл бүрийн үйлчилгээний хэлбэрийг дэмжих	Хамран сургалтанд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх	Хамран сургалт 90 хувь хувьд хүргэнэ.		Цэцэрлэг
2.2.4	Цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдийн дунд спортын тэмцээн уралдаан зохион байгуулах	Уралдааныг жилд 2 удаа зохион байгуулсан байна	эхчүүд, багш, ажилчдын уялдаа холбоо сайжирна		Цэцэрлэг
2.2.5	“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр	Хүүхэд залуучууд, насанд хүрсэн иргэдэд хүрч үйлчилсэн байна.		“Байдраг” ахлах сургууль Цэцэрлэг
2.2.6	Гэр цэцэрлэг гаргаж хувилбар сургалт зохион байгуулах	Хувилбар сургалтыг зохион байгуулсан байна	Сургуулийн өмнөх боловсролд хөдөөний хүүхдүүдийг бүрэн хамруулсан байна		Цэцэрлэг
2.2.7	“Монгол бичиг” сурах хөдөлгөөнийг өрнүүлж, “Монгол бичиг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Монгол бичгийн хэрэглээнд ахиц гарсан байна.	Албан хэрэг хөтлөлтөнд Монгол бичгийг хэрэглэж эхэлнэ.		Төсвийн бүх байгууллагууд
2.2.8	Бүх нийтийн “Англи хэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Иргэдэд англи хэлний зохих түвшиний мэдлэг олгосноор	Бүх нийтийн англи хэлний мэдлэг дээшилсэн байна		“Байдраг” ахлах сургууль
2.2.9	Гэр бүл, хувь хүн, нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн ажил, сургалт сурталчилгааны ажлыг хөгжүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	Сургалт сурталчилгаа зохион байгуулж, аливаа үйл ажиллагаанд олон нийтийг хамруулсан байна	Сургууль, иргэдийн уялдаа холбоо сайжирна		“Байдраг” ахлах сургууль



2.2.10	Уламжлал ёс заншилын танхимтай болох	Танхим тохижуулснаар	Ёс заншилын танхимтай болсноор хүүхдүүд ардын уламжлалт ёс заншил, түүх соёлд суралцана		"Байдраг" ахлах сургууль
2.2.11	Цэцэрлэгийн бүлэг бүрийг био суултуур/00/-тай болгох	Бүлэг бүр био суултууртай болсон байна	Ялангуяа хүйтэний улиралд хүүхдүүд гадаа гарч ханиад томуу хүрэхээс сэргийлж, тав тухтай орчин бүрдүүлнэ		ЗДТГ, ИТХ
2.2.12	Хүн амыг тогтвор суурьшилтай байлгах бодлого барьж ажиллана.	Бодлогыг барьж ажилласан байна	Орон нутагт бүртгэлтэй СӨБ, сургуулийн насны хүүхдүүдийг боловсролын хоцрогдолгүй хамруулсан байна		"Байдраг" ахлах сургууль, Цэцэрлэг, Улсын бүртгэгч
2.2.13	Албан бус боловсролын тогтолцоог сайжруулах	Сургалтанд ахиц гарсанаар	Сумын хэмжээнд байгаа бичиг үсэг тайлагдаагүй иргэд хамрагдсан байна		"Байдраг" ахлах сургууль, Багийн Засаг дарга нар
<b>3.Эрүүл мэндийн талаар:</b>					
2.3.1	Рентгэн аппарат	Рентген аппараттай болсон байна	Аливаа өвчин орон нутагтаа түргэн шуурхай оношлогддог болсон байна		Сум дундын эмнэлэг
2.3.2	Лабораторын тоног төхөөрөмж, аппарат	Лабораторын тоног төхөөрөмж, аппараттай болсон байна	Оношлогоо, шинжилгээг орон нутагтаа өгдөг болсон байна		Сум дундын эмнэлэг
2.3.3	Шүдний тоног төхөөрөмж	Шүдний тоног төхөөрөмжтэй болсон байна	Сумд шүдний өвчлөл багассан байна		Сум дундын эмнэлэг
2.3.4	Эрүүл мэндийн дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлэх	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог нэмэгдүүлсэн байх	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо 2-оор нэмэгдсэн байна		Сум дундын эмнэлэг
2.3.5	Эрүүл мэндийг дэмжигч өрхийн тоог	Эрүүл мэндийг	Эрүүл мэндийг дэмжигч		Сум дундын

	нэмэгдүүлэх	дэмжигч өрхийн тоог нэмэгдүүлсэн байх	өрхийн тоо нэмэгдсэн байх		эмнэлэг
2.3.6	Зорилтот бүлэгт чиглэсэн сургалтыг чанартай тогтмол хийж гүйцэтгэх	Сургалтыг зохион байгуулсан байна	Сургалт үр дүнгээ өгсөн байх		Сум дундын эмнэлэг
2.3.7	Сумын НЭМ-ийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх	НЭМ-ийн тусламж үйлчилгээний хүртээмж сайжирна.	Орон нутаг дахь эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, иргэдэд шуурхай үйлчилгээг үзүүлнэ.		Сум дундын эмнэлэг
2.3.8	Иргэний бүртгэл, Нийгмийн даатгал, багийн Засаг дарга нартай хамтран "Эрүүл өрх" аянг үргэлжлүүлэх	Алслагдсан хүн амд нотолгоонд тулгуурласан тусламж болон үйлчилгээний хүртээмж, эрүүл мэндийн даатгалд хамрагдалт нэмэгдэж, хүн амын бүртгэл сайжирч, өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийх бодлогын зөвлөмж гаргах боломж бүрдэнэ.	Нийт иргэдийн эрүүл мэндийн түвшинг тогтоож нарийн мэргэжлийн эмч нартай хамтран эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна.		Сум дундын эмнэлэг Нийгмийн даатгалын байцаагч Иргэний бүртгэлийн улсын бүртгэгч Багийн Засаг дарга нар
2.3.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан амралтын байрыг ашиглалтанд оруулж графикын дагуу амраах	Эмгэгтэд байрлах барилгын засварын ажлыг шийдвэрлэж, ашиглалтанд оруулах	Сувилалд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн суурь өвчтэй хүүхдийг хамруулж, өвчлөлийг багасгана.	Орон нутгийн хөгжлийн сангаас	Сум дундын эмнэлэг

2.3.10	Сумын амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн бага насны хүүхдийг хоол тэжээлийн архаг дутагдалаас үүсэх суурь өвчлөлийг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана	Хоол тэжээлийн архаг дутагдалаас үүсэх суурь өвчлөлийг бууруулахад чиглэсэн тодорхой, үр дүнтэй ажлууд хийгдсэн байна	Амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн бага насны хүүхдийг хоол тэжээлийн архаг дутагдалаас үүсэх суурь өвчлөл буурсан байна		Сум дундын эмнэлэг
<i>Гурав. Хүнс, ХАА, газар тариалан, МАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого:</i>					
3.1	"Монгол мал" дэд хөтөлбөрийн хүрээнд хээлтүүлэгч малын санг бүрдүүлэх	Сайн үүлдэр угсааны хээлтүүлэгч мал худалдан авсан байна	Малын үүлдэр угсаа сайжирсан байна		МЭУТасаг
3.2	Малжуулах бодлогыг хэрэгжүүлэх	Нийгмийн зорилтод бүлгүүдийн айл өрхүүдийг малжуулсан байна	5-аас доошгүй айлыг малжуулсан байна		Багийн Засаг дарга нар МЭУТасаг
3.3	Мал эмнэлгийн ажил үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд зөөврийн угаалгын ванн, хашаатай болох	Угаалгын ванн, хашаатай болсон байна	Малын халдварт өвчин багассан байна. Тарилга туулга хийхэд хүндрэл багатай болно.	Орон нутгийн хөгжлийн сангаас 5 сая	МЭУТасаг
3.4	ХАА-н маркетинг төслөөс бичил төслүүдийг санхүүжүүлнэ	Төсөл хэрэгжсэнээр	Өрхийн орлого нэмэгдсэн байна	ХАА-н маркетинг төслөөс	ЗДТГ, МЭУТасаг
3.5	Шинэ болон шинээр сэргэн гарах магадлал бүхий мал амьтны халдварт өвчнүүдийн талаар сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.	Сургалт сурталчилгаа хийгдсэнээр	Мал амьтаны гаралтай өвчлөл буурсан байна		МЭУТасаг
3.6	Тухайн жилд Засгийн газрын тогтоолоор заасан өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх	50тн-оос доошгүй нөөц бүрдүүлсэн байна	Өвөлжилтийн бэлтгэлийг 80-иас дээш хувиар хангасан байна	Гамшигийн сан бүрдүүлэх	МЭУТасаг



3.7	Бэлчээрийн хортон мэргэч устгах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж бэлчээр хамгаалах	Энгийн механик аргаар устгана	Бэлчээрийн даац сайжирсан байна	Орон нутгийн хөгжлийн сангаас	МЭҮТасаг, Багийн Засаг дарга нар
3.8	Мал сүргийг эрсдэлийн даатгалд хамруулах	Эрсдэлийн даатгалд хамруулсанаар	Малчин өрхийн 10-аас доошгүй хувь нь эрсдэлийн даатгалд хамрагдсан байна		МЭҮТасаг, Багийн Засаг дарга нар
3.9	Малчдын дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулна.	Урлаг спортын арга хэмжээ зохион байгуулагдсанаар	Малчдын дунд урлаг спортын арга хэмжээ зохион байгуулсанаар малчид болон төрийн албаны уялдаа холбоо сайжирна		Засаг даргын Тамгын газар, МЭҮТасаг
3.10	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, шаардагдах худгийг шинээр гаргах	Худаг шинээр гаргасан байна	Усны нөөц тогтоосон газар гүн өрмийн худаг гаргана.		МЭҮ-ийн тасаг
<b>Дөрөв: Сумын нийгмийн хамгаалал, эдийн засаг, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого</b>					
4.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Ажилгүй иргэдийг түр болон байнгын ажлын байранд зуучилах	Шинээр бий болгосон ажлын байрыг баталгаажуулж, өрхийн амьжиргаа дээшилнэ.		Сумын Засаг дарга Нийгмийн хөгжлийн ажилтан Халамжийн мэргэжилтэн
4.2	Иргэний андагай өргөх ёслолыг зохион байгуулах	Андгай өргөүүлсэнээр	Иргэний баримт бичгийн үнэ цэнэ нэмэгдэж, үүргээ ухамсарладаг болсон байна		Улсын бүртгэгч
4.3	Сумын төвийн айл өрх, албан байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн хашааг өөрчлөн өнгө үзэмж сайтай болгох	Аж ахуй нэгж байгууллагууд болон айл өрхийн хашааны өнгө үзэмжийг сайжруулан, нэгэн жигд болгох	Сумын төвийн өнгө үзэмж сайжирсан байна		Сумын засаг дарга, Нийгмийн хөгжлийн ажилтан, Багийн Засаг дарга, Байгаль хамгаалагч нар
4.4	"Жаргалантад үйлдвэрлэв-2015" үзэсгэлэн худалдааг зохион байгуулна	Үзэсгэлэн худалдааг зохион	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулсанаар		Нийгмийн хөгжлийн

		байгуулсан байна	нутгийн бренд нэрийн бүтээгдэхүүнтэй болсон байна		ажилтан, Төрийн болон Төрийн бус байгууллага
4.5	"Ажилтай орлоготой монгол хүн" үндэсний хөтөлбөр хөдөлмөрийн аяны үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөр хэрэгжүүлэх аяны хүрээнд 3-аас доошгүй удаа зөвлөгөөн зохион байгуулна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцно.		Сумын Засаг дарга Нийгмийн хөгжлийн ажилтан Халамжийн мэргэжилтэн
4.6	Засгийн газрын конвенцыг хэрэгжүүлэх хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдийн нөхцөл байдлын судалгаа хийх сургалт зохион байгуулах	Судалгаа гаргаж сургалт зохион байгуулсан байна	Конвенцын хэрэгжилт биелсэн байна.		Нийгмийн хөгжлийн ажилтан, халамжийн байцаагч, нийгмийн даатгалын байцаагч, Сум дундын хүн эмнэлэг
4.7	Гэр бүлийн гишүүд иргэдийн үүрэг ухамсар, төлөвшилийг дээшлүүлэх төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр өгөөж	Гэр бүл цаашлаад иргэдийн ухамсар, төлөвшил, хандлага өөрчлөгдсөн байна.		Сумын Засаг дарга Нийгмийн хөгжлийн ажилтан Халамжийн мэргэжилтэн
4.8	Гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурахтай тэмцэх зорилгоор "Эрүүл идэвхитэй амьдрал" клубыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагтай хамтран байгуулж, иргэдэд сумын ГХУСАЗЗөвлөлөөс сургалт явуулна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр өгөөж	Иргэдийн ухамсар, хандлага өөрчлөгдсөн байна.		Сумын Засаг дарга Нийгмийн хөгжлийн ажилтан Халамжийн мэргэжилтэн
4.9	Өрхийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдах өрхүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Үйл ажиллагаа тогтмолжсон байна	Өрхүүдийн амьжиргаа дээшилсэн байх		Нийгмийн хөгжлийн ажилтан

					Халамжийн мэргэжилтэн, Багийн Засаг дарга нар
4.10	Залуу малчдын дунд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулж, сургалтанд хамруулах	Урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулсан байна	Залуучуудын нийгмийн идэвх дээшилсэн байна		Нийгмийн хөгжлийн ажилтан, Багийн Засаг дарга нар, Залуучуудын холбоо
4.11	Нийгмийн 3 талт зөвшил 2015-2016 оны хэлэлцээрийг хэрэгжүүлж орон нутгийн хөгжилд төр, үйлдвэрчний байгууллага, ажил олгогчдын оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	Ажлын хэсгийн хуралдааны тоо шийдвэрлэсэн арга хэмжээний үр дүн	Хэлэлцээр тусгагдсан тухайн онд хийгдэх арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна.		Үйлдвэрчний эвлэлийн холбоо Байгууллагуудын арга эрхлэгч нар
4.12	Төр, үйлдвэрчин, ажил олгогч эздийн холбооны тэгш оролцоотой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонууд болон бусад салбар хороодын үйл ажиллагааг сумын түвшинд тогтмолжуулах	Салбар зөвлөлүүд байгуулсан тоогоор	Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь		Төсөвт байгууллагуудын ХАБЭАЗ-ийн дарга, Нарийн бичгийн дарга нар
4.13	Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 90 жилийг угтан Жаргалантын хүүхдүүд хүүхдийн урлагийн их наадам зохион байгуулах	Их наадам зохион байгуулагдсанаар	Хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж, авьяас чадвараа нээн хөгжүүлнэ		Нийгмийн хөгжлийн ажилтан, Соёлын төв
4.14	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт хувь	ХАБЭА орчин сайжирсан, өмнөх оноос 1-2 хувиар нэмэгдсэн байна.		Төсөвт байгууллагуудын ХАБЭАЗ-ийн дарга, Нарийн бичгийн дарга нар
4.15	ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээл болон сум хөгжүүлэх сангийн зээлийг үргэлжлүүлэн урьд онуудын эргэн төлөлтийг бүрэн ашиглаж үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх	Үйлчилгээний газрууд шинээр бий болж, ажлын байр нэмэгдэнэ.	Зээлийн эргэн төлөлт зарцуулалтанд хяналт тавиж үр ашигтай үйлдвэр үйлчилгээг бий болгоно.		Сумын Засаг дарга Нийгмийн хөгжлийн ажилтан
4.16	Төрийн албан хаагчид болон малчдын	Орон сууц	Сумд 24 айлын орон сууц		Сумын Засаг



	нийгмийн асуудалд анхаарч орон сууцжуулах бодлого барьж ажиллана.	баригдсан байна	баригдаж малчид төрийн албан хаагчдын амьдрах ая тухтай орчин бүрдэнэ		дарга Нийгмийн хөгжлийн ажлан, багийн Засаг дарга нар
4.17	Улсын болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	Орлогын төлөвлөгөөг 100 хувь хангана.	Татварын хуулийг сурталчилж, иргэн бүр төрөө дээдэлж татвар төлдөг зан үйлийг хэвшүүлэх		Төрийн сангийн мэргэжилтэн, Татварын улсын байцаагч
4.18	Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах дотоод хяналтын системийг бий болгох	Зөрчлийг 80 хувиар бууруулна.	Журмын дагуу төлөвлөгөө гарган удирдамж боловсруулж, хяналт шалгалтыг тогтмол хийдэг болсон байна.		Төрийн сангийн мэргэжилтэн, Төсөвт байгууллагуудын ня-бо нар
4.19	2014 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг хугацаа алдалгүй тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах	Тухайн ажлын онцлогоос хамаарч төлөвлөгөөний дагуу тендэр хугацаандаа бүрэн дууссан байна.	Тухайн онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг 100 хувь хуулийн дагуу худалдан авалт хийсэн байна.		Төрийн сангийн мэргэжилтэн, Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, ня-бо нар
4.20	Аймгийн вэб сайт-д зарлагдсан тендер сонгон шалгаруулалтын үр дүнг тухайн бүр байршуулан мэдээлэх	Тухайн бүр нь мэдээлнэ	Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.		Төрийн сангийн мэргэжилтэн, Төсөвт байгууллагуудын дарга, эрхлэгч, ня-бо нар
4.21	ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээ мэдээллийг цахим системд оруулж бүртгэлжүүлж тогтмол хяналттай болгох	Бүх мэдээллийг цахим санд оруулсан байна.	ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл хөтөлбөрийн мэдээллийг иргэдэд нээлттэй болгосон байна.		Төрийн сангийн мэргэжилтэн, Тамгын газрын ня-бо
4.22	Ня-бо бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг бүртгэлд авч	Хөрөнгийг бүртгэлд авч эзэнжүүлснээр	Хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сайжирсан байна.		Төсөвт байгууллагуудын ня-бо нар

	эзэнжүүлэх, гэрээ хэлцэл хийх				
4.23	Орон нутгийн өмчид байгууллагуудын үндсэн хөрөнгийг программд оруулж цахимаар хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг хийж тайлан мэдээг гаргах	Нийт байгууллагын хөрөнгийг программд оруулснаар	Байгууллагын хөрөнгийг 100 хувь программд оруулснаар		Төсөвт байгууллагуудын ня-бо нар
4.24	Статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах	Гарын авлага танилцуулгын тоо мэдээллийг гаргана.	Бүх хэрэглэгчийг мэдээллээр хангасан байна.		Төрийн сангийн мэргэжилтэн
4.25	Ажил олгогч сайн дур, эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөний биелэлтийг хангаж шимтгэлийн өр авлагагүй ажиллах	Шимтгэлийн өр авлагагүй ажилласнаар	Ажил олгогч НД-ын сайн дурын, ЭМД-ын даатгалын төлөвлөгөөг 100 хувь биелүүлснээр		Нийгмийн даатгалын байцаагч
4.26	Татварын албан бүртгэлтэй ААН-үүдийг бүртгэж шимтгэл төлүүлэх	ААН-үүдийг бүрэн хамруулснаар	Бүрэн хамрагдсан байна.		Нийгмийн даатгалын байцаагч
4.27	Сумд төв зам, явган хүний зам тавих	Явган хүний зам тавигдсан байна	Иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангаас 15 сая	Сумын Засаг дарга
4.28	Жуулчны гэр бааз байгуулах	Гэр бааз байгуулсан байна	Аялал жуулчлал хөгжиж, сум орон нутагт орлого орно		Сумын Засаг дарга
<b>Тав. Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого:</b>					
5.1	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, мод тарих, арчилах, тордох ажлыг хийж гүйцэтгэнэ	Ажлыг гүйцэтгэснээр	Цөлжилтын эсрэг тодорхой ахиц гарсан байна		БОХУ-ын байцаагч, Байгаль хамгаалагч нар, Байгууллагуудын дарга, эрхлэгч нар
5.2	Гар аргаар алт олборлоод орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ	10 га-д техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийсэн байна.		БОХУ-ын байцаагч, Байгаль хамгаалагч нар
5.3	Цөлжилтийг багасгах элсний нүүдэл саармагжуулах малын бэлчээр усыг	Цөлжилтийн эсрэг авч хэрэгжүүлсэн			БОХУ-ын байцаагч,

	хамгаалах	арга хэмжээний үр дүнгээр			Байгаль хамгаалагч нар
5.4	Булгагч шандын эхийг хамгаалах	Булгийн эхийг хамгаалснаар	Булгийн эхийг хамгаалснаар		БОХУ-ын байцаагч, Байгаль хамгаалагч нар
5.6	Ерөнхий боловсролын сурагчид болон иргэдийн экологийн боловсрол олгох "Эко" танхим байгуулах	Танхим байгуулж тохижуулснаар	ЕБС-ийн болон иргэдийг сургалтанд хамруулснаар экологийн боловсрол дээшилнэ.		БОХУ-ын байцаагч, Байгаль хамгаалагч
5.7	Орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг тэмдэгжүүлэх	Тэмдэгжүүлэлт хийгдсэнээр	Тусгай хамгаалалттай газар нутгийн бүрэн бүтэн байдал хамгаалагдсан байна		БОХУ-ын байцаагч, Байгаль хамгаалагч
5.8	Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, бүлэг байгуулж ажиллах	Нөхөрлөл, бүлэг байгуулагдсан байна	Байгаль орчиноо хамгаалахад иргэдийн оролцоо нэмэгдэнэ		БОХУ-ын байцаагч, Байгаль хамгаалагч
<b>Зургаа. Гадаад харилцааны бодлого:</b>					
6.1	УИХ-ын гишүүд, аймгийн хурлын төлөөлөгчтэй хамтран ажиллаж улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын төсөл хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх	Орон нутагт шаардлагатай хөрөнгө оруулалтын жагсаалт гаргаж УИХ-ын гишүүдэд уламжлах	Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтыг оруулах болно.		Сумын Засаг даргын Тамгын газар
6.2	Сум орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд, урлаг, спорт оюуны амжилт гаргаж буй өсвөр үе залуучуудад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох зорилгоор нутгийн зөвлөлүүдтэй хамтарч "Байдраг нутгийн хөгжлийн төлөө" сан байгуулж ажиллах	Сан байгуулж үйл ажиллагаа жигдэрсэнээр	Сан бүрдэж шийдвэрлэгдсэн байх		Сумын Засаг даргын Тамгын газар Нийгмийн хөгжлийн ажилтан





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар

2/15

Жаргалант

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:


1.Сумын 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг жилийн эцэст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/-д газрын даамал Ц.Мөнхтунгалаг нарт даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



Сумын ИТХ-ын Хуралдааны 2014 оны 4/15  
дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



НЭГ. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДЭВСГЭР ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Газрын хэмжээ /м/	Зориулалт	Техникийн нөхцөл	Хариуцах эзэн
1	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	"Маамуу нааш ир" цэцэрлэгийн хойд талд	X=536268.0722 Y=5207612.7129	501	Хуучин соёлын төв	Дуудлага худалдаа	Д.Сайнбилэг Ц.Мөнхтунгалаг
2	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	Засварын газрын баруун талд	X=536487.5550 Y=5207578.017 X=536486.6339 Y=5207582.8135 X=536492.8755 Y=5207584.1353 X=536493.8221 Y=5207579.2268 X=536487.5528 Y=5207578.0166 X=536486.6339 Y=5207582.8135	541	Агуулах	Гэрээгээр	Д.Сайнбилэг Ц.Мөнхтунгалаг
3	Жаргалант	Эмээл толгойн 4-р баг	Орон сууц хороололын нийтийн эзэмшлийн газарт	X=536422.3325 Y=5207657.5996 X=536436.9636 Y=5207660.9060 X=536434.7810 Y=5207670.6650 X=536420.1617 Y=5207667.3070 X=536422.3325 Y=5207657.5996	16.2	Худалдаа, үйлчилгээ	Гэрээгээр	Д.Сайнбилэг Ц.Мөнхтунгалаг






ГУРАВ. БЭЛЧЭЭРИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Бэлчээр ашиглалтын хэсгийн дугаар	Бэлчээр ашиглалтын хэсгийн нэр	Газрын байршлын нэр	Хамрагдах талбай /га /	Хийхээр төлөвлөж байгаа арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэн гүйцэтгэх	Төсөв, мянган төгрөгөөр			
							Иргэн, ААН Байгууллага	Төсвөөс	Төсөл, зээл, тусламж, хандив	
БАшиглалтын 9-р хэсэг	1-р баг	Давсан тал	1500	Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо		+		
БАшиглалтын 9-р хэсэг		Хөшгийн өвөр		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 9-р хэсэг		Улаан хуруу		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 9-р хэсэг		Хөндлөн хар		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 9-р хэсэг		Хөндлөн улаан		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 9-р хэсэг		Дөт		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 9-р хэсэг						Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо		
БАшиглалтын 2-р хэсэг	2-р баг	Нуур	1500	Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 2-р хэсэг		Хатавч		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 7-р хэсэг		Нам		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 4-р хэсэг	3-р баг	Нарийн тээл	1500	Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 4-р хэсэг		хүрэм		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 4-р хэсэг		Хавцгай		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 8-р хэсэг		Цохиот		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 3-р хэсэг		Хүрээний буурь		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				
БАшиглалтын 3-р хэсэг		Тэгш		Бэлчээрийн хортон мэрэгчид устгах		Малчдын бүлэг хоршоо				

Сумын ИТХ-ын Хуралдааны 2014 оны 4/15  
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**ЖАРГАЛАНТ СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ 2015 ОНЫ  
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Нэг. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн байршил.**

Баянхонгор аймгийн Жаргалант сум нь УБ хотоос 830 кмт, аймгийн төвөөс 163 км-т төвийн эрчим хүчний системд холбогдсон, хангайн уулархаг бүсэд оршдог.

Жаргалант сум нь аймгийнхаа баруун хойд хэсэгт оршиж хойд талаараа Архангай аймаг, зүүн урд талаараа Галуут сум, баруун урд талаараа Заг, баруун талаараа Гурванбулаг сумдын нутаг дэвсгэртэй тус тус хиллэнэ.

Жаргалант сум нь 4 багтай, 2014 оны байдлаар нийт 874 өрх, 2880 хүн амтай, 115090 толгой малтай, 417453 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай. 402775,65 га бэлчээртэй, 9083 га атаршсан газартай, 605 га тариалангийн талбайтай.

Байдраг, Мандал, Цохиот, Нуур, Хатавч зэрэг томоохон голууд, Биндэръяа Хөх Нуур, Завагийн нуур, Ногоон нуур, Давст Баян цагаан нуур гэх мэт нууруудтай ба Цохиот, Нуур, Өл, Уст, Ялаат зэрэг рашаан харз болон байгалийн үзэсгэлэнт газруудтай.

**Хоёр.Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага:**

Монгол улсын бэлчээрийн газрын 80% нь бэлчээрийн доройтолд ороод байгаа энэ үед БМТөлөвлөгөөг зайлшгүй боловсруулах шаардлагатай.

Жаргалант сум нь бэлчээрийн мал аж ахуйтай, бэлчээрийн даац хүрэлцээгүй байдаг учир мал бэлчээрлэхэд хүндрэлтэй болоод байна.

Зун намрын улиралд салхи шуурга ихтэй, хур тунадас бага ордог.

Бэлчээрийн талхагдал хомсдолтой энэ үед бэлчээр сэлгэх ч нутаггүй болоод байна.

Гол дагуух нутагт олон жил дараалан зусч намарждагаас бэлчээр их хэмжээгээр талхлагдаж ургамлын бүтэц өөрчлөгдөн мал тарга тэвээрэг авч чадахгүй байна.

Сумын дэвсгэр нутгийн голлох бэлчээрийн нутагт /1976-1990/ он хүртэл нэг наст ургамал тариалж байсан ба сүүлийн 20-иод жил атаршуулснаас бэлчээр нь ургамлын нөмрөггүй болж цөлжилтөнд нэрвэгдсэн газар нутаг болж үлдсэн.

Бэлчээрийн менежментийг хэр зэрэг үр ашигтай хэрэгжүүлэх нь бэлчээрийн төлөв байдал, чанарын үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно.

Энэ нь эцэстээ мал аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн өсөлт, бууралт, түүнийг дагаад малчдын амьжиргааны төвшингөөр илэрхийлэгдэнэ гэсэн үг.



Бэлчээрийг хэдий чинээ ойр ойрхон сэлгэж чадна тэр хэмжээгээр бэлчээрийг доройтлоос хамгаалж чадна.

Мал аж ахуйн салбарт бэлчээрийг хамгаалах зорилгоор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Байдраг голын сав, Мандалын Бөөрөгийн алт олборлолтын уурхай, Анаг, Уулзвар, Баруун, Зүүн салаа, Ар намд гар аргаар алт олборлолт явуулснаас газрын гүний ус, гол горхины урсгалд сөрөг нөлөө үзүүлэн улмаар бэлчээрийн болон отрын нөөц нутаг өртөөд байна.

Байдрагийн САА байхад манай суманд /1976-1990/ он хүртэл нэг наст ургамал тариалж байсан хадлангийн талбай одоо өвс ногоо ургахгүй атаршсан газар болсон ба тэр үед ажиллаж байсан тариаланч, механикжуулагчид маань атаршуулсан тариалангийн талбайд таримал бэлчээр бий болгох боломжтой юм.

Жаргалант сум нь бэлчээр ашиглалтын 9 хэсэгтэй. Нам толгойн 1-р багт бэлчээр ашиглалтын 5,6,9-р хэсэг, Өлзийт-Өндөрийн 2-р багт бэлчээр ашиглалтын 1,2,7-р хэсэг, Хөндлөн булагийн 3-р багт бэлчээр ашиглалтын 3,4,8-р хэсгүүд ордог.

2014 оны эцэст Нам толгойн 1-р багт 37730 толгой мал, Өлзийт –Өндөрийн 2-р багт 34965 толгой мал, Хөндлөн булагийн 3-р багт 31603 толгой мал, Эмээл толгой 4-р багт 10792 толгой мал тус тус тоологдлоо.

Сумын хэмжээнд 2014 оны байдлаар нийт 115090 толгой мал тоологдсоноос тэмээ 7, адуу 8097, үхэр 21492, хонь 46159, ямаа 39335 толгой мал тоологдон урьд оныхтой харьцуулбал 13962 толгой малаар өссөн дүнтэй харагдаж байгаа нь малчдын маань нөр их хөдөлмөрийн үр шим юм.

Жаргалант сумын хэмжээнд 2014 онд 9 мянгат малчинтай болсон бөгөөд 1-р багийн малчин Д.Соённямбуу 1051 мал, Д.Амарбаяр 1025 мал, Ё.Нямдаваа 1006 мал, 2-р багийн малчин У.Мэндбаяр 1088 мал, Б.Алтанхуяг 1240 мал, Д.Баттулга 1108 мал, Ц.Ойдовсамбуу 1023 мал, Б.Жүгдэр 1349 мал, Ж.Рагчаасүрэн 1206 мал тус тус тоолууллаа.

Сумын хэмжээнд “Хамгийн хамгийн” олон мал тоолуулсан малчидаар:

- ✓ 7 тэмээгээр Ц.Ууганхүү / 1-р багийн малчин /
- ✓ 120 адуугаар Б.Наранбаатар / 2-р багийн малчин /
- ✓ 375 үхрээр Цэндаюуш / 3-р багийн малчин /
- ✓ 999 хониор Б.Жүгдэр / 2-р багийн малчин /
- ✓ 465 ямаагаар Д.Соённямбуу / 1-р багийн малчин /
- ✓ Нийт малын тоогоороо хамгийн олон малтай малчинаар 2-р багийн малчин Б.Жүгдэр 1349 толгой мал тоолуулаад байна.



ЖАРГАЛАНТ СУМЫН СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛИЙН МАЛЫН ТООНЫ СУДАЛГААГ  
ХҮСНЭГТЭЭР ХАРЬЦУУЛБАЛ:

	2010		2011		2012		2013		2014	
	12	60	8	40	10	50	8	40	7	35
Тэмээ	5778	34668	5882	35292	6148	36888	7005	42030	8097	48582
Адуу	13032	78192	14478	86868	16140	96840	19172	115032	21492	128952
Хонь	30855	30855	31338	31338	36785	36785	39059	39059	46159	46159
Ямаа	29709	26738.1	31121	28008.9	29966	26969.4	35884	32295.6	39335	35401.5
<b>Бүгд</b>	<b>79386</b>	<b>170513.1</b>	<b>82827</b>	<b>181546.9</b>	<b>92227</b>	<b>197532.4</b>	<b>101128</b>	<b>268416,6</b>	<b>115090</b>	<b>259129,5</b>

Мал аж ахуйн салбарт бэлчээрийг хамгаалах зорилгоор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Мал маллагааны арга ажиллагаа өөрчлөгдсөн, бэлчээрийн ачаалал нэмэгдсэн, цөлжилт газар авч, бэлчээрийн талхагдал ихэссэн зэрэг нь сумын хэмжээнд бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүнийгээ жинхэнэ бодит ажил болгох явцыг хянаж үр дүнг олон түмэнд ил тод мэдээлж байх явдал юм.

**ЖАРГАЛАНТ СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ 2015 ОНЫ БЭЛЧЭЭРИЙН  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах эзэн	Зардлыг хаанаас санхүүжүүлэх
	1.1 Өвөлжөө, хаваржааны координатыг тогтоох	2-5 сард	Сумын засаг дарга, газрын даамал, Багийн дарга, БОУБайцаагч,	Орон нутгийн төсвөөс
	1.2 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг малын хөлөөс чөлөөлөх отор нүүдэл оруулахгүй байх	Жилдээ	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, БОУБайцаагч, ХАА-н мэргэжилтэн	Өөрсдийн санаачлагаар
	1.3 Улсын тусгай хамгаалалттай газар нутагт өвөлжөө, хаваржааны газар эзэмшиж байгаа иргэдийн эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох	2-6 сард	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, БОУБайцаагч, ХАА-н мэргэжилтэн, ТХГазрын байгаль хамгаалагч	
	1.4 Улсын сайн малчдын сууриар баг бүрээс малчдын төлөөллийг ажлын хэсэг болгон явуулж танилцуулж туршлага судлуулах	Жилдээ	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, БОУБайцаагч, ХАА-н мэргэжилтэн	Өөрсдийн санаачлагаар
	1.5 Улс, аймаг, сумын аварга малчинд тавигдах шаардлагыг малчдад таниулах, тэдэнд мэдээлэл өгөх		Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, БОУБайцаагч, ХАА-н мэргэжилтэн	Өөрсдийн санаачлагаар
Хоёр.Багийн ИНХ, багийн засаг даргын хэрэгжүүлэх ажлууд	2.1 Малчдыг бүлэг, хоршооны зохион байгуулалтанд оруулах, Бүлгүүдийн нэгдсэн мэдээллийн сантай болох	3-7 сарын хооронд	Сумын засаг дарга, багийн засаг дарга,ХАА-н мэргэжилтэн	Өөрсдийн санаачлагаар
	2.2 Өвөлжөө, хаваржааны газрыг хортон мэрэгчдээс хамгаалах	Жилдээ	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, малчид, ХАА-н мэргэжилтэн	Өөрсдийн хүчээр
	2.3 Ган, зуд байгалийн гэнэтийн аюул гарсан үед яаралтай арга хэмжээ авах	Тухайн үед нь	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, малчид	Баталсан төсвийн хэмжээгээр
	2.4 Бэлчээрийн даац, багтаамжийг 8-р сард багтаан баг бүрээр тогтоон мал өвөлжилт хаваржилтын төлөвлөгөөг боловсруулж багийн дарга нараар дамжуулан малчдад хүргэн нүүдэл суудлыг зохион байгуулах	6-8-р саруудад	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, малчид	Өөрсдийн санаачилгаар
	2.5 Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун, намрын улиралд чөлөөлөх, хамгаалах ажлыг зохион байгуулах	6-9-р саруудад	Сумын засаг дарга, багийн засаг дарга, газрын даамал, байгаль хамгаалагч, малчид	Өөрсдийн хүчээр

	2.6 Хөдөөгийн 3 багтай төрийн болон төрийн бус байгууллагуудыг холбон шөлийн холбоо тогтоон тэдэнд мөл төллөх болон цаг агаарын хүнд нөхцлүүдэд хүн хүчээр туслах	Жилдээ	Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн засаг дарга, байгаль хамгаалагч, Малчдын бүлгийн ахлагч	Өөрсдийн санаачлагаар
	2.7 Малгүй өрхийг малжуулж, ажлын байр амьдралын захтай болгож байгаа тэргүүний малчдын судалгааг гаргаж тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлыг анхан шатны Улаан загалмайн байгууллагууд багийн дарга нартай хамтран зохион байгуулах	Жилдээ	Сумын засаг дарга, багийн засаг дарга, нийгмийн ажилтан газрын даамал	Өөрсдийн санаачлагаар
Гурав. Багийн ИНХ, багийн засаг даргын хэрэгжүүлэх ажлууд	3.1 Малчдыг бүлгийн зохион байгуулалтанд оруулах, багийн хурлаар багийн отрын нөөц нутгийг бий болгох асуудлыг хэлэлцүүлж багийн ИНХурлын шийдвэр гаргуулах	6-р сард багтаан	Багийн ИНХурал,Багийн засаг дарга	Өөрсдийн хүчээр
	3.2 Ган, зудын үед өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх асуудлыг судалж, сумын Засаг даргад танилцуулах	Тухайн үед нь	Багийн ИНХурал, Багийн засаг дарга, малчид	Өөрсдийн санаачлагаар
	3.3 Багуудын өдөрлөгөөр газрын тухай хуулийг сурталчилах, бэлчээрийн газрын эзэмшлийн талаар малчдын хооронд гарсан маргааныг зохицуулна. /Малчдын хоорондоо зохицож байгаа маргаан үүнд хамаарахгүй./	Тухайн үед нь	Багийн ИНХурал,Багийн засаг дарга,малчид	Өөрсдийн санаачлагаар
	3.4 Өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүх малчид, малчидын бүлгээс нэгтгэн авч судалгаа тайланг тамгын газарт ирүүлэх	9,10-р сард	Багийн ИНХурал,Багийн засаг дарга,малчид	Өөрсдийн санаачилгаар
	3.5 Бэлчээр ашиглах уламжлалт тогтолцоог сэргээн ашиглаж бэлчээр нутгаа талхагдалд орохоос сэргийлж доройтож муудсан бэлчээрийг 2-3 жил мал бэлчээхгүй түүнийг тордон сайжруулах чиглэлээр санаачлага гаргаж ажиллах	жилдээ	Багийн ИНХурал,Багийн засаг дарга,малчид	Өөрсдийн санаачилгаар
	4.1 Малчид өөрсдийн хүчээр хашаа хороогоо засварлах, шинээр барих, гар тэжээл бэлтгэх, өвөлжөө, хаваржаа зуслан намаржааныхаа газарт тусгай хогийн цэг, жорлонтой болох	жилдээ	Багийн ИНХурал, Багийн засаг дарга, байгаль хамгаалагч, малчид	Өөрсдийн хүчээр



<p>Дөрөв. Малчид, малчдын бүлгийн хариуцан хэрэгжүүлэх ажлууд</p>	<p>4.2 Малчид, малчдын бүлгүүд мал сүргээ эрсдлээс хамгаалах сан бүрдүүлж ажиллах</p>	<p>жилдээ</p>	<p>Малчид, малчдын бүлгйн ахлагч</p>	<p>Өөрсдийн санаачлагаар</p>
	<p>4.3 Малын толгойн тоо төрлийн харьцааг бэлчээр нутгийнхаа даацанд тохируулан барьж хэрэгцээнээс илүү зах зээлд борлуулж хуримтлалаа нэмэгдүүлэх</p>	<p>Жилдээ</p>	<p>Малчид, малчдын бүлгийн ахлагч</p>	<p>Өөрсдийн санаачлагаар</p>



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 4/16

Жаргалант

Орлого хуваарилах тухай

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Байдраг ахлах сургуулийн захирлын 2014 оны 138 дугаар албан бичгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Байдраг ахлах сургуулийн өөрийн үйл ажиллагааны орлого 3210000 төгрөгийг дараах зардалд хуваарилсугай. Үүнд:

№	Зардал	Байдраг ахлах сургууль
1	Аж ахуйн эд хогшил	1620,0
2	Урсгал засвар	1590,0
	Нийт	3210,0

2.Төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга Д.Сайнбилэг, Байдраг ахлах сургуулийн захирал С.Оюун нарт даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



15120147



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар

4/17

Жаргалант

Тайлангийн тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс 2013 онд хийсэн ажлын тайланг хэлэлцээд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс 2014 онд зохион байгуулсан ажил, үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс батлан гаргаж буй тогтоол, шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Сайнбилэг/-д даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТӨМӨР



1512675  
togtool-2014